

Монгол дахь шинэ шашнуудын номлол сургаал, үйл ажиллагаа

С.Тайвансүрэн- Шашин судлалын магистр

Түлхүүр үг: шашин, мормон, бахай, баптизм, адвентизм, Шри Чинмой, Ананда Марга, Рава Шанкар, Сума Чинхай

Шашин нь хүний оюун ухаан хөгжихийн хэрээр хувьсан шинэчлэгдэж байдаг. Үүний тод илрэл бол уламжлалт шашин, шинэ шашин гэдэг ойлголт юм. Уламжлалт шашин гэдэг нь үндэсний шашин гэдэгтэй адил төстэй утгатай, гэхдээ бас ялгаатай авч үзвэл зохих ойлголт юм. Аль нэг угсаатан, үндэстэн, улс оронд түүхийн нилээд урт удаан хугацаанд оршин тогтнож, үзэл номлол, үйлдэл шүтлэг нь үндэсний уламжлал, ёс заншилд нэвчин шингэж, ахуй амьдралд нь идээшин дасаж, аажмаар тухайн улс үндэстний болон ард түмний соёлын салшгүй содон шинж, үндсэн элемент болон төлөвшиж, улмаар тэр соёлыг дараа үеийнхэнд дамжуулан хэвшүүлж байдаг тийм шашныг уламжлалт шашин гэх нь бий. Цаг хугацааны хувьд харьцангуй саяханаас үүссэн үзэл номлол, ихэвчлэн гаднаас орж ирж байгаа, эсвэл тухайн нийгмийн огцом өөрчлөлт буюу хямралт байдлын үр дагавар болон гарч ирж байгаа, эхэн үедээ нийгмийн зүгээс олонхийн дэмжлэг, хүндэтгэлийг төдий л хүлээгээгүй тийм шүтлэгийн хэв маягийг шинэ шашин гэдэг.

Монгол орны хувьд шинэ шашин гэдэгт шинээр дэлгэрч буй шашны урсгал чиглэлүүдийг хамааруулж тэдгээрийн нийгэмд эзлэх байр суурь, шүтэн бишрэгчдийн хүрээ, үйл ажиллагаа, зан үйлийн онцлог зэргийг харгалзан үзэж тэдгээрээс доорх 8 шашнуудыг сонгон. Эдгээрийг үзэл баримтлал, зан үйлийн шинжээр нь нэгтгэн доорх байдлаар:

Нэгдүгээрт: Өрнийн уламжлалтай шинэ шашнууд: “Мормон”, “Бахай”, “Баптизм”, “Адвентизм”

Хоёрдугаарт: Дорнын уламжлалтай шинэ шашнууд: “Шри Чинмой”, “Ананда Марга”, “Рава Шанкар”, “Сума Чинхай” хэмээн ангилж, тэдгээрийн үндэслэгчид, үзэл номлолын онцлог, үйл ажиллагаа зэргийг тодруулан авч үзье.

Өрнийн уламжлалтай шинэ шашнуудын номлол сургаалын онцлог

Мормоны шашин буюу Есүс Христийн хожуу үеийн Гэгээнтнүүдийн сүм:

Орчин үед нөлөө бүхий шинэ шашнуудын тоонд Мормоны шашин ордог. Энэ шашин анх 1832 онд “Христийн сүм” гэдэг нэрээр Америкд анх үүссэн. Үндэслэгч Джозеф Смитт /1805-1841/ юм. Энэ хүн 1820 оноос эхэлж өөрийгөө бурханы илч гэдгээ ухаарч ойлгож ярих болсон. 1829 оноос Джозеф Смитт-ыг Тэнгэрлэг элчээр хүлээн зөвшөөрсөн сүсэгтэнүүдийн хүрээлэлтэй болсоноор идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тэрээр номлолын үйл ажиллагаа явуулаад зогсохгүй ном бичиж эхэлсэн. Тухайлбал: **“Мормоны ном”, “Гэрээслэл”, “Сувдан сондор”** зэргийг дурьдаж болно.¹¹⁴ Тэрээр өөрийгөө тэнгэрийн зарлигаар бичсэн номыг олох үүрэгтэй байсан гээд эдгээр номыг олж нийтэд хүргэж байна гэх болсон энэ үйл ажиллагаагаа 10 гаруй жил явуулсан. Мормоны шашны түгэн дэлгэрэхэд ихээхэн нөлөөлсөн хүн бол Брайм Яг /1801-1877/ тэрээр уг шашны санваартанууд • сүсэгтэнүүдийн • баримтлалыг • системчлэн • боловсруулсан. Америкийн засгийн газраас 1870 онд Мормончуудын гэрлэлтийн эсрэг хууль

¹¹⁴ “Лиахона-Судар судалсанаас авах зүйл” Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм УБ., 2007

гаргасан ч Мормончууд идэвхтэй тэмцэж 1880 онд харилцан тохиролцож шинэ хууль гаргуулж авчээ.

Мормоны шашины үзэл сургаалын гол агуулга нь тэнгэрлэг номлолыг хүлээн зөвшөөрч гэмээ наминчлах тухай сургаал юм. Зан үйлийн хувьд:

1. Загалмайлах ёсыг хүлээн зөвшөөрөх
2. Ариун санваартнуудын адис хүртээх ёс
3. Мормоны ариун гэрлэлт
4. Рашаан хүртэх ёс гэсэн 4-н гол зан үйлийн баримталдаг.¹¹⁵

Мормоны шашны өөр нэг онцлог бол нас барсан хүмүүсийг загалмайлдаг явдал юм. Мормончууд бие биедээ байнга хяналт тавьж үргэлж хоёулаа явдаг. Мормонын шүтэгчид 13 зарчмыг баримталдаг.

1. Тэнгэрлэг элчийн шинжийг хүлээн зөвшөөрөх ёстой
2. Хүн бүр зэмлэл хүлээх ёстой
 1. Бүх хүн төрөлхтөний аврагч бол мормончууд байх ёстой
 2. Евангелийн хуулийг хатуу баримтлах ёстой
 3. Хүн ба бурханы хүлээн зөвшөөрөх ёстой
 4. Анхдагч сүм хийдийн баримталж байсан тэр дэг жаяг зохион байгуулалтыг дагах ёстой
 5. Бурхантай харилцах ер бусын хэлийг мэдэх ёстой
 6. Библи бол бурханы үг мөн гэдэгт итгэх ёстой тиймээс зөв орчуулагдах ёстой /өөрийн номлолын мөн чанарт тохируулж/
 7. Тэнгэрлэг элч нээнэ гэдэгт итгэх ёстой
 8. Израйль жинхэнэ ёсоор мандан бадрах ёстой гэдэгт итгэх ёстой
 9. Гадаад хүмүүс ч гэсэн биднийг шүтэн буй сургаальд нь итгэж хүлээн зөвшөөрөх ёстой тийм учраас Мормончууд өөрсдийн бололцоогоор хичээн зүтгэх үүрэгтэй
 10. Тэнгэр элчид захирагддагын нэг адил хуульд захирагдах ёстой
 11. Сайн сайхан шударга үнэнд итгэх ёстой

Шүтэн бишрэгчидийнх нь баримталдаг эдгээр зарчмууд Мормоны шашны үзэл сургаалынх нь онцлогыг илтгэн харуулж байгаа юм. Уг шашны тэргүүнийг "Есүс Христын Хожуу Үеийн Гэгээнтнүүдийн" сүмийн ерөнхийлөгч хэмээн нэрлэдэг. Одоогийн ерөнхийлөгч нь АНУ-н иргэн Гордон Хинкли (2006 онд сонгогдсон). Түүний удирдлага доор дээд зөвлөл /коллеги/-ийн 82 гишүүнтэй байгуулага ажиллаж, дэлхийн улс орнууд дахь Үндэсний төвүүдэд удирдамж илгээдэг. Мормоны шашин нь АНУ, Англи, Сканданевын орнууд, Австри, Швейцарь, Шинэ Зеланд, Герман, Британи, Орос, Испани, Африк зэрэг дэлхийн 100 гаруй оронд үндэсний төвтэй дэлхий дахинд 15 сая Мормончууд байдагаас зөвхөн Америкт л гэхэд 150 гаруй "Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн" сүм байдаг. Эдгээр сүмүүд нь олон үндэстэний итгэгчидэд зориулан цуглаанаа Польш, Навахо, Орос, Испани, Герман зэрэг 20 хэлээр явуулдаг байна.¹¹⁶ Монголд 2002 оноос "Есүст Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм" нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн нийгмийн нилээд өргөн хүрээг хамарч буй шинэ шашин юм. Улаанбаатар хот дахь төв сүм нь СХД-ийн 1 хороонд байрладаг. Нийслэлийг 4 бүст хуваан 4 салбар сүмүүдэд гишүүд дэмжигчидийн цугларалтыг зохион байгуулдаг. Шинэ гишүүдийг элсүүлэх ажил нилээд зохион байгуулалттай явагддаг тухайлбал: Шинээр гишүүн элссэн дохиолдолд уг гишүүнд дараагын цугларалт, мэдээ зэргийг уг дүүрэг хороог хариуцсан пастор гэрээр нь хүргэж өгөх сонирхсон хүмүүст <Авралын зар> сургалтыг гэр болон байгуулгуудад зохион явуулах. Мормончуудынхаар хичнээн хүнийг авралын замд хөтлөнө тэр хэрээр өөрөө

¹¹⁵ "Мормоны ном" Есүс Христийн Хожмын Үеийн Сүм УБ., 2004

¹¹⁶ "Лиакхона-Тэдний мөрөөр" Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм УБ., 2007

аврагдана гэсэн шашныхаа сургаал ёсоор баримтлагчид нь ч шинээр гишүүн элсүүлэх тал дээр идэвхтэй ажилдаг. Уг сүмд гадаадын олон орноос пасторууд ирж үйл ажиллагааг нь дэмжиж хэлний болон гишүүнчлэлийн сургалтууд хүмүүнлэгийн ажилууд зохион байгуулдаг Монголын үнэн сүсэгтнүүдээ гадаадын орнууд дхаь шашны сургуульд /пасторын/ явуулах өөрийн шашны томоохон төвүүдтэй танилцуулах зэргийг зохион байгуулдаг нь сүсэгтнүүдийн анхаарлыг ихээр татдаг. Хүүхдүүдэд зориулсан сургалтууд:

- Сүмийн дэргэд англи, герман, франц хэлний сургалт
- Урлаг соёлын дугуйлан
- Юбка оёж сурцгаая, гар урлалын сургалт
- Хөгжмийн мэдлэг олгох сургалт гэх мэт сургалтуудыг зохион явуулдаг.

Насанд хүрэгчдийн цуглаан 3,5,6 өдрүүдэд тогтмол явагддаг уг цуглаан – Мормоны номыг унших, библид тайлал хийх, дуулал шүлгийн уран уншлага зохиох, бүх хүн төрөлхтөний төлөөх нийтийн залибарал гэсэн ерөнхий агуулгатай явагддаг. Манайд дэлгэрсэн шинэ шашнуудаас сүсэгтэнүүдэн хүрээлэл явуулж буй үйл ажиллагааныхаа цар хүрээгээрээ нийгэмд нилээд танигдсан шинэ шашин юм.

Бахайн шашин. “Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга”. Бахайн шашинд үзэхдээ бурхан гэдэг нэг л байдаг. Харин бурхны нэрлэж, зурж төсөөлж болохгүй, түүгээр оролдох хэрэггүй, харин бурхан бол цаг ямагт илч илээдэг. Түүнийг нь зарим нь ойлгодоггүй учраас одоо болтол олон шашин дэлгэрсээр байна. “Будда, Христ, Мухаммад, Кришна, Зороастр зэрэг агуу тэнгэрлэг айлдагч нар дэлхийд оюун санааны нар болон мандаж, хүмүүсийн харанхуй ухааныг гэгээрүүлж, нойрмог сэтгэлийг нь сэрээсэн шашны эдгээр үндэслэгчидийг бид хүлээн зөвшөөрөх ёстой”¹¹⁷ харин бурханы илч нь Баха-улла юм. Бурхны шашны бол зөнч мэргэдийн тооруулагч үүрэгтэй. Бурханы илч мөн бурханы гэрээсийн дамжуулагч үүрэгтэй. Гэрээсийг их гэрээс бага гэрээс гэж 2 хуваана. Бага гэрээс бол бурханы илчийн номлол сургааль, их гэрээс бол бурханы хүн төрөлхтөнд зориулсан сургааль юм. Бага гэрээсэнд бурханы илч бол өөрийнхөө залгамжлагчдын тодруулах ёстой гэж үздэг. Бахайн шашны зан үйл баримтлах зарчим гэдэгт:

1. Мөргөл орно заавал хийх үйлдэл учир нь бурхантай харьцах гол үйлдэл учир мөргөлийг а/урт б/дунд в/богино
2. Мацаг барих бурханд үнэнчээ шалгуулах тэвчээрээ шалгуулах үйлдэл
3. Бахайн сургаал номлолын дэлгэрүүлэх нь бусад хүмүүст үзүүлэх дээдийн үйлчилгээ гэх үздэг. /бурханы сургаалын дэлгэрүүлэх нь өвчтэй хүнд эм түгээхтэй адил/¹¹⁸
4. Согтууруулах ундаанаас татгалзах
5. Бахайн шашны ариун дурсгалт өдрүүдийг тэмдэглэх явдал бахайн шашинтай хүний гол зарчим /Шашны өдрийг сүсэгтэн олон нэгдэн тэмдгэлсэнээр хамтын хүчээр хүн төрлөгтөний сайн сайханы төлөө сэтгэл санаагаа зориулж, улмаар Дэлхий ертөнцийг нэгэн бүхэл бурханы бүтээл гэдгийг ойлгох болно/¹¹⁹

¹¹⁷ Эсселемонт Ж.Э., “Бахаулла ба шмнэ эрин” МБҮОСЧуулга УБ., 2006 хуу 6 үзнэ үү

¹¹⁸ “Бахауллагын сургаалын дээжис” МБҮОСЧуулга УБ., 1998 үзнэ үү

¹¹⁹ “Бахайн шүтлэг” МБҮОСЧуулга танилцуулга УБ., 2003 хуу 10

6. Ариун гэрлэлт. Абдул Бахайн хэлсэнээр: Миний нэрийг дуусгах хүнийг төрүүлэхийн тулд та заавал гэрлэх хэрэгтэй. Гэрлэх нь бурханы өмнө хүлээсэн ариун үүрэг юм. Гэрлэлт нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дураар явагдах ёстой."Бахайн гэрлэлтэнд хоёр тал бие биетэйгээ оюун санаагаар ч тэр, бие махбодиор ч тэр бүрэн нэгдэж, бурханы бүх ертөнцүүдэд мөнхийн нэгдэлд хүрэн бие биеийнхээ оюн санааны амьдарлыг сайжруулах ёстой"¹²⁰
7. Ариун цэвэрийн сахих явдал, эрүүл мэнддээ хордуулах юм хийж болохгүй.
8. Өглөг өргөл барих. Өглөг өгөх нь өгөөмөр зангийн илрэл биш бурханы өмнө хүлээсэн үүрэг юм.¹²¹

Бахайн шашны дээд удирдлага нь "Даян дэлхийг удирдах шударга ёсны ордон" гэж Израйлын Хайфе хотод байрладаг. Энэ шашны удирдлага буюу захирагчдын зөвлөл нь 4 жилд нэг удаа сонгогддог. Ингэхдээ 153 орны 6 сая гаруй бахайчуудаас сонгогдсон 1000 төлөөлөгч Хайфедахь "Даян дэлхийг удирдах шударга ёсны ордон"-д цугларч нууц санал хураалтаар явагддаг. Сүүлийн сонгууль нь 2008.4.29 болсон. Үндэсний оюун санааны чуулган, орон нутгийн оюун санааны чуулган гэж байдаг. Тус бүр ёсон хүний бүрэлдэхүүнтэй жил болгон сонгогддог. Эрдэм мэдлэгтний зөвлөл нь дараах шатлалтай.

- Олон улсын судалгааны төв
- Тивийн зөвлөл
- Улс орон бүрд зөвлөл байдаг
- Орон нутагт туслах зөвлөл байдаг.

Манай оронд 1988 оноос Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга нэртэйгээр номлол сургаал, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Улаанбаатар дахь төв нь Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга нэртэйгээр / Сүхбаатар дүүрэг 2-р хороо 25-р байр 2 тоот/ үйл ажиллагаагаа явуулж байна. МБҮОСЧуулга нь олон нийтэд болон өөрийн шүтлэгтэнүүдэд мэдээлэл өгөх, гэр бүлийн уулзалт зохион байгуулах, гадаад хэл дээр хэвлэгдэн гарсан бахайн шашны номуудыг орчуулан гаргах, хүмүүнлэгийн ажлууд, пасторуудын сургалт зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Бахайн шашны орон нутагууд дахь салбарууд: Хөвсгөл, Завхан, Ховд, Өвөрхангай, Дархан, Өмнөговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Орхон, Сэлэнгэ, Баянхонгор, Говьалтай, Өмнөговь, Баянөлгийд /сумдуудад пионерууд буюу пасторууд тодорхой хугацаагаар томилогдон ажилдаг/ "Бахайн шүтлэгийн анхан шатны чуулга" нэртэйгээр үйл ажиллагаагаа идвэхтэй явуулж байна. Эдгээрт зохиогддог сургалтууд нь:

-Хүүхдийн хичээл 5-12 насныхан (Бахаулагын хэлсэн үлгэрүүдийг уншиж өгөх хүүхдэд багаас нь ёс суртахуунт бахайн шүтлэгтэн болгон төлөвшүүлэх)

-Өсвөр нас 12-18 насныхан (Бахайн сургаалыг уншиж танилцах, хөгжим, найрал дуу, гар урлал болон сүүдэр жүжиг зэрэг урлаг, гар урлалын сургалтад хамрагддаг)

-Насанд хүрэгчид 18 түүнээс дээш насныхан (Бахайн сургаалыг судлах шинээр гарсан ном сургаалд тайлал хийх, Олон улсын бахайн чуулгаас ирсэн илгээлтийг уншиж танилцах бусад орны бахайчуудтай холбоо тогтоох) гэсэн ангиллаар явагддаг.

Бахай шашны нэг гол онцлог нь шүтлэгийн сүм хийд гэж байдаггүй, түүнийг орлох Мөргөлийн ордон тив бүрт байдаг сүсэгтэн заавал тодорхой газарт цугларч мөргөл хийх шаардлагагүй бөгөөд өдөрт өөрийн боломжтой газраа мөргөлөө үйлдэнэ зарим тохиолдолд бахайн гэр бүлд цугларч хамтдаа мөргөл хийдэг

¹²⁰ Эссемонт Ж.Э., "Бахаулла ба шинэ эрин" МБҮОСЧуулга УБ., 2006 хуу 156

¹²¹ Эффенди Ш., "Бурхан хажуугаар өнгөрхүй" МБҮОСЧуулга УБ., 1998 үзнэ

үүнийг төвөөс нь зохион байгуулдаг. Бас нэг онцлог зүйл болох бахайн гэрлэлт 2007-2008 онд гэхэд Улаанбаатарт 5 хос бахайн гэрлэлтээ хийж, гэрчилгээ авсанаар бахайн ариун гэр бүл болсон байна. Одоогоор монголд 6000 маянга гаруй бахайн шашинтан байна гэсэн баримт байдаг.

Баптизм. “Бүх нийтийн Христчин Баптистуудын нэгдэл”. Энэ шашныг үндэслэгч нь Жон Смит /1554-1612/. Баптизм нь 1611 онд Ангилд үүссэн бөгөөд үндсэн утгаараа 1639 онд АНУ –д дэлгэрсэн. Уг шашны анхны ном нь **“Ангилчуудын итгэл үнэмшил ба Голландын Амстердам дахь үргэлжлэл”** гэсэн нэртэйгээр гарсан. Баптизмын гол баримталдаг ном нь **“Исүс Христийн итгэл үнэмшлийг өвлөх нь”** нэртэй. Баптизмын гол үзэл сургаал нь:

- Христийн авралын тухай сургаал
- Сүүлчийн оройн зоогийн тухай сургаал
- Баптизм хүртээх буюу усан баталгааны тухай сургаал(Усан баталгааг зөвхөн сайн дурын үндсэн дээр насанд хүрсэн хүнд хийнэ)
- Эрх чөлөө буюу хүн хамгийн эрхэм болох тухай сургаалууд байдаг¹²²

Библийн сургаалийг үндсэн номлолоо болгодог ингэхдээ өөрсдийн үзэл баримтлалд тохируулан тайлбар хийдэг. Энэ шашны үзэл сургаалын онцлог нь :

1. Есүс Христийн итгэл үнэмшлийг өвлөх
2. Эзэн тэнгэрийн сургаалыг үргэлжлүүлэн, өвлөх
3. Эзний төлөөх үнэн нулимсыг үзүүлэх
4. Өөрсдийн хайртай хүмүүсийн сүнсийг аврах
5. Дэлхийн хүмүүсийг зөв замд хөтлөх (Эзний замаар хүн төрлөхтөнийг хөтлөх нь бидний үүрэг)¹²³
6. Шашны ариун өдрүүд, Эзний өдрийг тэмдэглэх (Ням гариг)
7. Эзэнд үнэнчээ мөргөлөөрөө илчлэх
8. Эзний ариун ахан дүүс бололцох

Баптистуудын нэг хэсэг нь уламжлалт христийн шашны бүхий л сургаал номлолыг итгэн дагагчид байдаг бол нөгөө хэсэг нь баптизмын гол баримтлалуудыг дагаж мөрдөгсөд байдаг байна. Баптизм нь одоо дэлхийн олон орнууд болох Азиин зарим орнууд, Африк, Америкт “Бүх нийтийн Христчин Баптистуудын нэгдэл” нэртэйгээр номлол сургаал, үйл ажилагаагаа явуулж байгаа бөгөөд нийт 50 сая Баптистууд байдаг гэсэн баримт байдаг. Монголд 2003 оноос “Христэд Итгэгч Баптист Сүмийн Нэгдсэн холбоо” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн олон нийтийн анхаарлыг нилээд татаж буй шинэ шашин юм. Манайд баптизмын 8 сүм байдаг. Эдгээрийн удирдлагуудын нэгдсэн “Христэд Итгэгч Баптист Сүмийн Нэгдсэн Холбоо” нэртэй байгууллага ажилладаг. Уг байгуулгаас шашнаа сурталчлах хүрээн дор олон нийтэд хандсан нилээд ажлуудыг зохиодог үүнд: Залуучуудын нэгдсэн семинар, Эмэгтэйчүүдийн нэгдсэн семинар, өнчин, ядуусыг тэтгэх, архи тамхины эсрэг сургалт сурталчилгаа, танилцуулга болон ном хэвлэл гаргах¹²⁴ гэх мэт. Улаанбаатарт Баптист шашны 2 томоохон сүм байдаг бөгөөд эхнийх нь БГД-ийн 16-р хороонд “Шулуун зам баптист” нэртэйгээр үйл ажилгаагаа явуулаж байна. Уг сүмийг Жейсон Муллер /2006 онд байгуулагдсан/. Хоёр дахь нь СХД-ийн 18-р хороонд “Улаанбаатар баптист төв сүм” нэртэйгээр үйл ажилгаагаа явуулдаг. Сүмийг Ким Ху Чань /2005 онд байгуулагдсан/. Баптист шашны эдгээр сүмүүдийн зохион байгуулаж буй сургалт, цугларалтууд:

... Залуу, ээжүүдийн сургалт.(Хүүхдийг хэрхэн эзний хүн болгох, хүмүүжлийн талаар) ...

¹²² Юу Хан И., “Христэд итгэгчдийн залбиралт амьдрал” БНХБНэгдэл УБ., 2005

¹²³ Юу Хан И., “Бурханы нигүүлслийн сайн мэдээ” БНХБНэгдэл УБ., 2004

¹²⁴ “Улаанбаатар Баптист Төв Сүм” ийн Дотоод баримтаас: Орон нутаг дахь салбар сүмүүд болон гишүүдийн тоо зэргийг авсан болно.

Дүүргүүдийн аав, ээж, залуучуудын нэгдсэн нөхөрлөл (дотроо жижиг бүлэгт хуваагдан бүлгийн ахлагчид тухайн өдрийн мөргөлийн болон зарлагдсан үндсэн сэдвийн дагуу ярилцлагыг удирдан явуулдаг)

Залуу гэр бүлүүдийн нэгдсэн уулзалт (гэр бүлүүдийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдэх)

Залуучуудын нөхөрлөл уулзалт (Эзний ариун ахан дүүсийн эв нэгдэл сэдэвт) гэх мэтээр насны ялгаагаар, хүйсийн ялгаагаар, зарим тохиолдолд тахир дутуу иргэдийн зэрэг ялгаатайгар эсийн бүлэг буюу тодорхой зохион байгуулалт бүхий бүлгүүдэд хуваагдаж цуглаан явуулдаг.

Эсийн бүлэг нь итгэгчдийн нийтлэг байдалд үндэслэн зохион байгуулагддаг учраас нэг талаас ойлголцол, нөгөө талаас сүмийн гишүүдийн эв нэгдэл, бие биедээ тавих анхаарал халамж зэргийг нэмэгдүүлж, улмаар энэ нь итгэгчдийн итгэлийг дээшлүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлдэг бололтой. Цуглаанаас гадна спортын тэмцээн, зугаалгууд, хөдөө орон нутагийн салбар сүмүүдын гишүүдтэйгээ хамтарсан мөргөл нөхөрлөлүүд явуулдаг. Дээрх сургалт цуглааны зар нь танилцуулага хэлбэрээр 7 хоног бүр хэвлэгдэн гарч өөрийн бүртгэлт гишүүдэд хаягаар нь тараагддаг. Монгол дахь баптистуудын ихэнх хувийг залуу гишүүд эзэлдэг /Улаанбаатар Баптист Төв Сүмийн хувьд байнгын 300 итгэгчийн 80% нь 16-22 насныхан байдаг/ тэдгээрт зориулсан үйл ажиллагаа голлон явуулдаг.

Адвентизм “Долоо дахь өдрийн Адвентист сүм”. XIX зууны эхэн үед АНУ-д христос шашнаас улбаалан үүссэн. Үндэслэгч нь Уильям Миллер (1782-1849). Түүний гол бүтээл нь **“Ариун судрын номолгоо ба Христийн 1000-н жилийн үргэлжлэл”** библийн зарим сургаал номлолд тайлбар хийх хэлбэрээр бичигдсэн уг ном нь Адвентистуудын гол баримтлал болдог. Мөн библин шинэ гэрээний Иохан, Матай, Лук, Марк ¹²⁵ зэрэг бүлгүүдийн сургаал номлолыг голчлон баримтладаг. Ингэхдээ өөрсдийн үзэл баримтлалд тохируулан тайлбарлах буюу эдүгээчилдэг. Адвентист шашны сургаал номлолын хэд хэдэн онцлог байдаг. Үүнд:

1. Энэ ертөнцөд хийсэн сайн муу үйлийн хариу нь шүүлтийн өдөр ирдэг
2. Шүүх өдөр буюу “Аймшигт шүүлт” ирнэ гэдэгт итгэх
3. Оюун санаа үхдэггүй, бие махбод үхсэн мэт болдогч Христийн “Долоо дахь өдөр” дахин амьладаг
4. Дэлхий дээрх амьдрал бол Долоо дахь өдөрт бэлтэх бэлтгэл төдий зүйл
5. Долоо дахь өдөр ариун өдөр гэдэгт итгэх
6. Өргөл барьц өрөг (Бүх бүтээгдэхүүнийхээ дээжээр болон эд хөрөнгөөрөө Эзэнд өргөл өгч дээдэл ¹²⁶)
7. Адвентистууд ойрын галавын үеийн 1000 жилдээ оршин олширсоор байна гэдэгт итгэх
8. Бүх хүмүүст авралын зар тараагдах ёстой. Есүс бидэнд “явж бүх үндэстнийг дагалдагч болгогтун” ¹²⁷ гэсэнчлэн

Адвентистууд библийн сургаалын “Долоо дахь өдрийн” тухайх сургаалыг номлолынхоо үндсэн баримтлалыг болгодог бөгөөд энэ өдөр ариун шүүлт явагдаж ариутгалд орсон хүмүүс өвчин зовлон энэ ертөнцийн муу бүхнээс хагацна гэж үздэг. “Долоо дахь өдөр” бол ажил төрөл, үүрэг даалгавараа идэвхитэй хийж гүйцэтгэн биелүүлэх өдөр уг өдөр хүн бүр хөдөлмөрлөх ёстой ингэснээрээ шүүлт ирэхэд ариусан үлдэж чадна гэж номолдог. Адвентист шашин нь дэлхийн олон орнууд болох Америк, Африкийн орнууд, Орос, Солонгос, Япон,

¹²⁵ “Ариун библи” Монголын Библин Орчуулгын Хороо УБ., 2000 тал 1,50,81,134

¹²⁶ Паулсен Ж., “Даниелын нууцыг тайлсан нь” Долоо дахь өдрийн Адвентист сүм УБ., 2006

¹²⁷ Антони Г., “Дагалдагч байх нь” Долоо дахь өдрийн Адвентист сүм УБ., 2008 тал 106

Тайвань, Малайзд дэлгэрсэн ойролцоогоор 2.5 тэр бум Адвентистууд байдаг¹²⁸ байна.

Монголд үйл ажилгаагаа явуулаад төдийлөн удаагүй шинэ шашин бөгөөд Чингэлтэй дүүргийн 5 хороонд “Долоо дахь Өдрийн Адвентист сүм” нэртэйгээр /2006 оноос/ үйл ажилгаа явуулж эхэлсэн. Энэ сүмийн үйл ажиллагааны цөм нь ням гаригт зохион байгуулдаг их эзэнд зориулсан хүндэтгэлийн цуглаан юм. Цуглаан нь хүүхэд, өсвөр үеийнхний, насанд хүрэгчдийн гэсэн ангилалтайгаар явагддаг. Цуглаан нь:

- Магтаал дуу (Гишүүдын Эзэнд зориулж дуу, шүлэг, магтаал хэлдэг)
- Пасторийн яриа (Библид өөрсдийн үзэлд нийцүүлэн утгын тайлбар хийдэг)
- Залбирал (Доор бий)
- Мэдээ мэдээлэл (Ирэх цуглаануудын зар мэдээнүүд)
- Эзэнд өргөл өргөх (Цуглаанд ирсэн хүн бүр мөнгөн өргөл өгдөг) гэсэн үндсэн хэсгүүдээс бүрддэг.

Магтаал дуу, шүлэг өргөх гишүүд, пасторийн тоо зэргээс хамаарч 2-3 цаг үргэлжилдэг.

Адвентистуудын үзэл сургаалын онцлогыг багтаасан дуу, шүлэг мөргөл залбиралууд нилээд байдаг эдгээрээс залбиралын агуулгыг товч дурьдвал:

- Сайн мэдээ дэлхий дахинд хүрэхийн төлөө
- Монгол орныхоо хөгжлийн төлөө /эдийн засаг, засгийн газар, ард түмэн/
- Хуурамч шүтээн, шашин шүтлэгийн эсрэг
- Адвентистуудынхаа сүнслэг өсөлт, зөн харааны төлөө
- Шинэ хүмүүсийн итгэлийн төлөө
- Сүмийн итгэгч бүр авралын зар тараагч болохын төлөө¹²⁹ гэх мэтээр залбирдаг.

Дорнын уламжлалтай шинэ шашин, бясалгал:

Шри Чинмой Шри Чинмой өөрийгөө “Орчин үеийн оюун ухааны багш” гэж нэрлэсэн. 1931 онд Бенгалид төрсөн. 1964 онд Нью-Йоркд ирж сургаал номлолоо уншихдаа. Энэтхэгийн уламжлалаар үнэ төлбөргүй уншдаг байсан нь хүмүүсийг татах гол түлхэц нь болж өгсөн. Шри Чинмой өөрийгөө ямар нэг шашинд хамаардаггүй гэж зарладаг. Түүний үзлээр, хүн болгон зовлонгоос гарах чадвартай гэж үздэг. Тэрээр өөрийн дотоод туршлагад үндэслэн оюун санаандаа эрэл хайгуул хийсний үр дүнд гарсан зүйл ба миний сургаал юм¹³⁰ гэсэн байдаг.

Түүний сургаалын үндэс нь цорын ганц бурхан болох хүний тухай бөгөөд хүн бурхантай адил боловч түүнийгээ мэдэрдэггүй. Түүнийгээр бурхан гэдэг нь эцэс төгсгөлгүй ухамсар өөрийгөө гэрэлтүүлдгээрээ энэ нь тэнгэр газарт хаан ч гэрэлтэй байдаг ингэхээр ухамсар буюу үнэт түүний хээр жинхэнэ шашны гол үндэс болдог гэж. Хүн өөрийгөө дотроосоо эхлэн аварч чадна. Тиймээс хүн өөрөө аврагч бөгөөд амьдралын ямар нэг зүйл болохгүй тохиолдолд бусдыг юм уу урьд насан дахь өөрийн үйлдэлээ буруутгах хэрэггүй гэжээ. Түүнийхээр хамгийн дээд зүйл бол хайр юм. Хайрлах гэдэг ойлголт нь өөрийгөө золиослож бусадтай нэгэн цогц болох гэсэн ойлголт байдаг. Хүн өөрийгөө дотроосоо аврахын тулд цэвэр ариун оюун санааг нээж олох хэрэгтэй. Үүнийг бясалгалын тусламжтайгаар хийж болно. Энэ бол бурханлаг байдлын гол түлхүүр юм.

Хүн энэ бясалгалаар хичээллэсэнээр дотоод байдлаа сэргээж энгийн аж жаргалтай • үнэний • замыг • нээх • боломжтой • болдог • гэжээ. • Шри • Чинмой • бясалгалаар “бурханыг мэдрэх зүрхийг бурханыг сонсох чихийг бурханыг харах

¹²⁸ “Adventist world”, The International Paper for Seventh- day Adventists USA., 2005

¹²⁹ “Танилцулга” Долоо дахь өдрийн Адвентист сүм УБ., 2008

¹³⁰ Larson B., “World Religions and Alternative Spirituality” USA., 2004 p 461

нүд бугу бурханыг байгаагаар нь мэдрэх болно” гэж номлодог. Тэрээр хүн өөрийн бурханыг танин мэдсэнээрээ ямар их зүйлийг зохиож бүтээж болохын тод жишээ бол би гэсэн байдаг. 1200 ном, 15 мянган аягуу /түүний хөгжмийг сонссон хүн бурханлаг зүйлийг мэдрэх болно гэжээ / 150 хөгжмийн зэмсэгээр тоглож чаддаг¹³¹ гэнэ. Энэ бүх зүйлээ би хийгээгүй харин тэр миний дээдийн дээд бурханы надад дамжуулж хийсэн зүйлс би бол тэр бурханаа зэмсэг нь юм гэжээ.

Чинмой бясалгалын хичээлээс гадна ажил, амьдрал спортын төрлөөр дэлхийд алдартай 8300 гаруй хүмүүсийг өрөгсөн үүгээрээ олон нийтэд танигдсан манай спортын алдартнууд болох Асашёрюү, Сумъяабазар нарыг Нью-Йорк хотноо очиход нь өргөж “Хорвоо дэлхийг эвийн сэтгэлээр өргөө” шагналыг өгч байсан. Энэ шашин нь АНУ, Орос, Герман, зэрэг олон орнуудад үйл ажиллагаагаа идэвхтэй явуулдаг бөгөөд дэлхий нийтэд 300 гаруй төвүүдтэй.

Монголд уг шашин нь “Чинмой бясалгал” нэртэйгээр 1995 оноос Чингис дээд сургуулийн байранд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Шри Чинмой нь манай оронд 2007.5.17-нд ирсэн энэ үеэрээ ерөнхийлөгч Энхбаяртай уулзаж, бэсрэг наадам зохиож, МҮОНТ-ийн сэтгүүлч Алтангэрэл зэргийн урлаг соёлын олон хүмүүсийг өргөж, 300 гаруй хүмүүсийг хамарсан нийтийн бясалгал зохион байгуулсан. Монголд байх хугацаанд нь түүний тухай сонин хэвлэлд 30 гаруй ярилцлага, өгүүлэл, сурвалжлага нийтлэгдсэн. Мөн телевизийн 30 орчим ярилцлага, сурвалжлага гарсан. Эрдэнэт, Дархан хстуудад салбар бясалгалын төвүүдтэй. Эдгээр төвүүдэд бясалгалын хичээл, Эрүүл хооллолтын сургалтууд, 1-3 сарын түр бясалгалууд явагддаг.

Ананда Марга “Аз жаргалд хүрэх зам”. Шри шри Ананда мурти үндэслэсэн. Хинди шашнаас улбаатай. Монголд олон нийтийн анхаарлыг татаж буй шинэ шашны урсгал юм. “Аз жаргалд хүрэх зам” гэсэн утгатай Ананда марга хэмээх хинди шашны нэгэн урсгал 1955 онд Энэтхэгт үүсжээ. Түүнээс хойшхи хугацаанд идэвхитэй үйл ажиллагаа явуулж, одоо дэлхийн 150 оронд өөрийн салбартай, сая гаруй гишүүдтэй болжээ. Ананда марга нь <нийгэмд үйлчилж, энэ дэлхий дээр эрүүл амьдрах арга барил болон сүнсний ажлын дадлыг зааж сургадаг. Ингэснээрээ хүний дотоод болон гадаад ертөц тэнцвэрждэг>¹³² гэжээ. Үүнээс гадна хүн сэтгэлийн бясалгал, йогийн дасгалын тусламжтайгаар өөрийн сэтгэл санаа, зан үйл, хэв заншлыг хянан жолоодож, оюун санааны сул талыг даван туулж, амьдралын нуугдмал, хязгааргүй их далд хүчийг олж авах бөгөөд ингэснээр ертөнцийн хүлээснээс ангижирч, хязгааргүй аз жаргалд хүрэх зам мөр нээгдэнэ гэж үздэг байна.

Энэ шашны нийгмийн үзэл сургаал нь боловсролыг дээдлэх, ядуусыг тэтгэх, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах, нийгэм ахуй, хүрээлэн байгаа орчны зөв зохицлыг олох, урлаг уран зохиол, эдийн засгийн, хүмүүнлэгийн онолоор дамжуулан нийгмийг боловсронгуй болгох явдал юм. Энэ шашны зарим салбар, бүлгүүд нэлээд экстремист шинжтэй нууц үйл ажиллагаа явуулах, улс төрийн халдлага хийх, өс хонзон авах зэрэг зохисгүй үйлдэлд оролцсоны улмаас Энэтхэгийн засгийн газар болон олон нийтийн дургүйцлийг хүргэж байсан.

1992 оноос “Монголын Ананда марга нийгэмлэг”, “Монголын оюутны Ананда марга холбоо” зэрэг байгууллагууд бий болсон. Тус нийгэмлэг, холбооноос гаргадаг “**Аз жаргалын эрэлч**”, “**Тэмүүлэхүй**” зэрэг жижиг сонин, сэтгүүлд буй ажлаа мэдээлж, үзэл санаагаа сурталчилдаг. Уг шашны төв нь 5-р сургуулын дэргэд “Ананда Йог” нэртэйгээр /Энэтхэг багш Дата, Ангил багш Амурт нар

¹³¹ “Танилцуулаг” Чинмой бясалгал

¹³² “Танилцуулаг” Ананда марга төв

удирдан/ Хүүхэд залуучуудын дунд англи, герман хэл, гүн ухаан, нийгмийн ухаан, бясалгал, йогийн дасгалын хичээл зохион байгуулах, тус шашныг үндэслэгч Саркарын амьдрал, үйл ажиллагаа, ном зохиолыг судлуулахын зэрэгцээ Ананда марга-ын гишүүний дагаж мөрдөх, баримтлах ёс журам, сахил санваарыг зааж сургах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Уг шашны явуулаж буй өөр нэг үйл ажилгаа нь эмчилгээ сувилгааны төв юм. Энэ нь Чингэлтэй дүүрэгт "Ананда Йог сувилал" нэртэйгээр:

- Йог бясалгал
- Зүү төөнүүр
- Бариа засал
- Физик эмчилгээ
- Эмчийн үзлэг гэх мэтийн йог, бясалгал, сургалтанд тулгуурласан эмчилгээ сувилгаа явуулдаг. Уг төвөөр үйлчлүүлж буй хүмүүсийн ихэнх хувийг өндөр настанууд эзэлдэг.

Мөн түүнчлэн олон нийтийн бусад байгууллагуудтай хамтран төрөл бүрийн ажил зохиож, нийгэмлэгийн болон шашныхаа нэр хүндийг өргөх байр сууриа бэхжүүлэх, хүрээгээ тэлэхийг эрмэлзэж буй шинэ шашин юм.

Рави Шанкар "Амьдрах ухаан". Энэ шашныг үндэслэгч нь Рави Шанкар. Уг шашин 1982 онд Энэтхэгт "Амьдрах ухаан" нэртэйгээр үүссэн. Рави Шанкар-ыг дагачид түүнийг бидний амьдарч буй эрин зуунд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн гэгээрлийн хутгийг олсон гурван хүний нэг гэж үздэг.

Түүний үндэслэсэн "бясалгал, йогын дасгал техникийг хийснээр хүн сэтгэлийн амар амагланг мэдэрч, аз жаргалтай сэтгэл хангалуун амьдарч чадна гэж"¹³³ сургадаг. Рави Шанкар өөрийн шашнаа шинжлэх ухааны үндэслэлтэйгээр "Хүнийг хувь хүнийнх нь хувьд бүхий л талаар нь хөгжүүлж бие эрүүл, сэтгэл ариун, ухаан саруул, амьдралын аль ч нугачаанд хөл нийлж алхах тэнхээтэй болгодог" арга теникийн цогц хэмээн тодорхойлсон. Рави Шанкарын бясалгал, йог, амьсгалын дасгалын тусламжтайгаар хүн жинхэнэ амралтыг мэдэрч, бие болоод сэтгэл оюунаа эрч хүчээр сэлбэж, стрес, ядаргаагаа тайлах хялбар арга барилыг богино хугацаанд сурах боломжтой гэж үздэг байна. Энэ шашны нийгмийн үзэл нь ядуусыг тэтгэх, нийгмээс тусгаарлагдагчдыг сургах, эрүүл мэндийг хангах, хүмүүнлэгийн онолоор дамжуулан нийгмийг боловсронгуй болгох явдал юм.

Уг шашин нь Ази, Европ, Австари, Өмнөд ба хойд Америк, Сингапур, Японд зэрэг 156 оронд салбар төвүүдтэй¹³⁴ тэдгээрт доорх сургалт, хичээлүүд болох:

- Амьсгал, Ус, Авиа хичээл
- Хүүхдийн хичээл
- Анхан шатны бясалгал хичээл
- Урьд насны бясалгал
- Тарнтай бясалгал
- Дээд курс

Олон нийтийг хамарсан:

- Тэнгэрлэг ариун нийгэм байгуулъя
- Удирдах ажилтан, бизнесменүүдэд зориулсан хичээл
- Хүүхдийн хичээл
- Хүчирхийллийн эсрэг хичээл
- Шоронгийн хүмүүст зориулсан хичээл

¹³³ Шанкар Р., "Амин голын залбирал" Олон улсын Шри Шри Амьдрах ухаан бясалгалын төв УБ., 2000

¹³⁴ Үйл ажилгааны талаарх мэдээлэлүүдийг дотоод танилцуулгаас

Дохтой хүмүүст зориулсан хичээл зэргийг зохион явуулдаг байна. Монголд уг шашин нь “Амьдрах ухаан” нэртэйгээр 1996 оноос Улсын клиникийн төв эмнэлгийн дэргэдэх байранд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Эрдэнэт, Дархан, Донод, Сүхбаатар, Хэнтий, Завхан, Говь-Алтай зэрэг 17 аймагт салбар төвтөй. Эдгээрт: – Дээд курс

– Урьд насны бясалгал

– Тэнгэрлэг ариун нийгэм

байгуулъя зэрэг байнгын болон 1-3 сарын сургалт, курсыг үнэ төлбөртөйгөөр зохион явуулдаг. Мөн түүнчлэн олон нийтийн байгууллагуудтай хамтран тухайлбал: улаан загалмайн нийгэмлэгтэй хамтарч зуданд нэрвэгдсэн малчдад туслах, Батсүмбэрийн асрамжийн газарт материаллаг тусламж болон анхан шатны сургалт, “5h” хөтөлбөрийн хүрээнд: Хоригдлууд, Ядууст, Өнчин хүүхдүүд, Өрөх толгойлсон эмэгтэйчүүд, Халдварт өвчтөй хүмүүст зориулсан сургалт хүмүүнлэгийн ажилуудыг зохиож шашныхаа нэр хүндийг өргөх, байр суриа бэхжүүлэх, нийгмийн хүрээлэлээ тэлэхийг эрмэлзэж буй шинэ шашин юм.

Чин Хай “Аръяабал бясалгал”

Энэ шашныг үндэслэгч нь Чин Хай Ау Лакт. Уг шашин нь 1985 онд АНУ-д “Аръяабал бясалгал” нэртэйгээр үүссэн. Тэрээр өөрийгөө “Хүн төрлөхтөнийг гэгээрлэлд хүргэх зорилготойгоор цаг үе бүхэнд их багш нар болох Шагжмуни, Мухамед, Есүс төрөн гарсан тэдгээрийн адилаар энэ цагт төрөн гарсан их багш”¹³⁵ гэж зарласан. Түүний номлол сургаал нь буддын шашнаас улбаатай боловч христийн шашны зарим нэг элементүүд болох хорвоо ертөнц болон хүний үүслийн талаарх сургаалыг ч авч хэргэлсэн нь бий. Чин Хай олон арван ном, зохиол, сэтгүүлүүд, шүлгийн түүвэрүүд бичсэн бөгөөд энэ шашны үзэл баримтлалыг багтаасан гол бүтээл нь 4-н дэвтэр бүхий:

<Агшин Зуур Билэг Нээгдэхийн Түлхүүр “Лөгц”>

<Агшин Зуур Билэг Нээгдэхийн Түлхүүр “Асуулт хариулт”>

<Агшин Зуур Билэг Нээгдэхийн Түлхүүр “Долоон өдрийн даян”>

<Агшин Зуур Билэг Нээгдэхийн Түлхүүр “Чангуухи ертөнцийн нууц”>

хэмээх номнууд нь юм. Эдгээр нь дэлхийн 18 хэл дээр орчуулагдан гарсан байдаг. Чин Хай өөрийн шашныг “Хүний туйлын зорилго болох Чангуухи ертөнц буюу Гэгээрэлд хүргэх хамгийн амар хялбар арга бол Аръяабалын бясалгал” хэмээн тодорхойлсон байдаг. Чин Хайн хэлэхдээ: Хүн болгон гэгээрэлд хүрэх боломжтой ингэхийн тулд амьд сэрүүн гэгээрсэн багшийг дагах хэрэгтэй хэрэв миний бясалгалын аргаар гэгээрэлд хүрхээр шийдсэн бол авшиг буюу сахил хүртэх ёстой. Авшиг хүртэхэд цээрлэх 5 сахил бий үүнд:

1. Амьтаны амь хөнөөхийг цээрлэх /амь хөнөөсөн хүнсний зүйл болох мах, загас, өндөг идэхгүй/
 2. Худал хэлэхгүй
 3. Хулгай хийхгүй
 4. Садар самууныг цээрлэх /Гэгэж секс, Эхнэр нөхрөөс гадуурх харицааг/
 5. Мансууруулах хорт бодис /Архи, тамхи, хар тамхи/ гэх мэтийг хэрэглэх ёсгүй.
- Түүнийхээр бясалгалын эцсийн зорилго бол бурхантай нэгдэх буюу Чангуухи ертөнцөд хүрэх ингэхийн тулд хүн олон ухааны 5 ертөнц буюу түвшнийг туулсанаараа хүн амьдарлаа өөрөөр харж уур бухимдалгүй, хүсэл шуналгүй, амар амаглан болох болно. Хүн хэдийгээр гэгээрсэн ч газар дэлхий дээр ирсэн томилолтоо дууссахыг тэвчээртэй, эв найртай хүлээдэг үүнийг эдүгээх төрөлдөө туулан тонилгох гэдэг гэжээ. Чин хайн шашин нь АНУ, Герман, Хятад, Тайланд, Солонгос, Япон зэрэг дэлхийн олон орон төвтэй бөгөөд тэрээр “Олон улсын Чин Хайн нийгэмлэг” байгууллагаа удирдан гамшиг, өлсөглөн, халдварт өвчинд

¹³⁵“Сума Чин Хай” .. Аръяабалын бясалгалын Улаанбаатар- Билгүүн төв УБ., 2006

нэрвэгдсэн улс орнуудад хүмүүнлэгийн ажилыг өргөн хүрээтэйгээр зохион байгуулдаг¹³⁶. Түүний сургаал номлолууд ном, DVD, CD, цуврал сэтгүүл хэлбэрээр хэвлэгдэн олон хэл дээр орчуулагдан үнэ төлбөргүй тараагддаг. Мөн түүнчлэн хиймэл дагуулаар ИТТВ-хойд америк, Канад, Ази номхон далай 27 оронд, Доминикан, Куба зэрэг орнуудад 30 гаруй хэлээр хадмал орчуулагатайгаар тодорхой цагуудад цацагддаг нь энэ шашны дэлхий нийтэд танигдах, хүрээлэлээ хурдацтай тэлэх гол нөхцөл болдог. Монгол оронд 2003 оноос “Аръяабал бясалгал” нэртэйгээр БГД-н 2-р хороонд үйл ажилгаа явуулж эхэлсэн нийгмийн нилээд өргөн хүрээг хамарч буй шинэ шашнуудын нэг юм. Улаанбаатарт төвтөйгөөр Эрдэнэт, Дархан, Зүүнхараа, Хөтөл, Өмнөговь, Налайх, Багануур салбар төвүүдэд:

–Дөхөм аргын бясалгал

–Авшиг хүртэгсэдийн бясалгал заадаг

Аръяабалын бясалгалын Улаанбаатар-билгүүн төвөөс санаачлан 2006 онд монголын 300 авшигтанг Тайванд болсон Чин Хайн бясалгалд хамруулсан байна. “Аръяабалын бясалгалын” төвийн дэргэд “Төгс гэгээрсэн их багшийн” телевиз, ангил хэлний сургалт, цагаан хоолны газар зэрэгт энэ шашны танилцуулга хуудас, сэтгүүл, ном хэвлэлүүд үнэ төлбөргүй тараагдах гэх мэтээр мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан шашнаа сурталчилах ажлыг идвэхтэй явуулж буй шинэ шашин юм.

Ном зүй

Судалгааны болон лавлагааны ном зохиол

- Антес П., “Религий совоеменности история и вера” М., 2001
- “Атейстический словарь” М., 1983
- “Всемерная энциклопедия философи” М., 2000
- Jerald C., “Dictionary of church history” USA., 1998
- Larson B., “World Religions and Alternative Spirituality” USA., 2004
- Цэдэндамба С., “Монгол улс дахь шашны нөхцөл байдал” УБ., 2003
- “Энциклопедия религий мира” М., 1999
- Яблоков И.Н., “Религиоведение” М., 2001

Шашнуудын ном зохиолууд

- Абдул Баха “Учир нь тайлагдсан зарим асуудал” УБ., 1999
- “Ананда Марга- Танилцуулга” УБ., 2008
- “Ариун библи” Монголын Библийн Орчуулгын Хороо УБ., 2000
- “Аз жаргалын элч” Ананда марга холбоо УБ., 2006
- “Бахай Шүтлэг -Танилцуулга” МБҮОСЦуулга УБ., 2003
- “Бахауллагийн сургаалын дээжис” МБҮОСЦуулга УБ., 1998
- “Бүхий л зовлон муу санаанаас үүдэлтэй” Аръяабалын бясалгалын төв УБ., 2006
- Джозеф С., “Мормоны ном” УБ., 2004
- “Жилийн тайлан ризван” МБҮОСЦуулга. Дотоод тайлан УБ., 2007
- “Их Багш Чин Хай” Аръяабалын бясалгалын УБ -Билгүүн төв УБ., 2006
- Лиахона -Ариун сүм” Есүс Христийн Хожмын Үеийн гэгээнтнүүдийн сүм УБ., 2007
- Лиахона -Судар судалсанаас авах зүйл” ЕХХҮСүм УБ., 2005
- • • • • “Лиахона -Тэдний мөрөөр” ЕХХҮСүм УБ., 2007 • • • • •
- “Лиахона -Өсч байгаа гэрчлэлийг тэжээн тэтгэх нь” УБ., 2007
- “Лиахона –Эцэг эх байна гэдэг дэлхийн хамгийн агуу сорилт” УБ., 2005
- Махназ Афшин “Хайрт багш” УБ., 1999

¹³⁶ “Төгс Гэгээрсэн Их Багш” Аръяабалын бясалгалын Улаанбаатар- Билгүүн төв УБ., 2005

- "Мормоны ном буюу есүс христийн бас нэг гэрээ" ЕХХҮСүм УБ., 2004
- "Мүнийн ёс" Эв нэгдлийн Монголын сүм УБ., 2006
- Перкинс М., "Алдарын Өдөр" УБ., 1999
- Перкинс М., "Үүр гэгээрэх цагаар" УБ., 1999
- "Төгс Гэгээрсэн Чин Хай" Аръяабалын бясалгалын төв УБ.,
- Чин Хай ., "Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр-Чангуухи ертөнц" УБ., 2006
- Чин Хай ., "Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр-Долоон өдрийн даян" УБ., 2005
- "Шри Шри Рави Шанкар" Амьдрах ухаан төв УБ., 2000
- "Эв нэгдлийн Монголын сүм- Танилцуулга"
- Эсслемонт Ж..Э., "Бахаулла ба шинэ эрин" УБ., 2006
- Эффенди Ш., "Бурхан хажуугаар өнгөрхүй" УБ.,